

НИЙТИЙН НОМЫН САНГИЙН ТӨЛБӨРТ ҮЙЛЧИЛГЭЭ

УНШИГЧИЙН КАРТ НЭЭХ-2000

ГЭРЭЭР НОМ ОЛГОХ-300 / 1ХОНОГИЙН /

ТӨЛБӨР ТУШААХ БАЙГУУЛЛАГЫН ДАНС: ТӨРИЙН САН 100220035022

Хөгжлийн бэрхшээлтэй болон хөдөөгийн багийн иргэдэд үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлнэ.

АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.ХИШИГДОРЖ

2024 оны дугаар сарын 05 ны өдөр

ГЭРЭЭР НОМ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭЛ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Говьсүмбэр аймгийн Нийтийн Номын Сангаас гэрээр ном олгоход энэхүү журмыг дагаж мөрдөнө.
- 1.2 Энэхүү журам нь номын сангийн үйлчилгээг хүн бүрт хүртээмжтэй хүргэх зорилготой.
- 1.3 Энэхүү журмыг ном хэвлэлтэй харьцаж буй номын санч, уншигч бүр дагаж мөрдөнө.

ХОЁР. ГЭРЭЭР НОМ ОЛГОХ ТУХАЙ

- 2.1 Гэрээр ном олгохдоо 2-оос дээш хувьтай номыг олгоно.
- 2.2 Гэрээр ном олгох үйлчилгээгээр ганц хувь, толь бичиг, үнэт ховор ном, лавлах материал, тогтмол хэвлэлийг олгохгүй.
- 2.3 Номыг 1-5 хоногийн хугацаатай олгоно.
- 2.4 Ном ашигласны төлбөр нэг хоногт 1 ном 300 төгрөгөөр тооцно.
- 2.5 Номын сан нь бүх нийтийн амралтын өдөр болон зайлшгүй шаардлага гарсан үед ажиллаагүй бол тухайн өдрийн төлбөрийг хасаж тооцно.
- 2.6 Гэрээр олгосон номыг нэг удаа сунгана.

ГУРАВ. УНШИГЧИЙН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 3.1 Уншигч нь гэрээр ном хэвлэл авахдаа иргэний үнэмлэх барьцаална.
- 3.2 Уншигч нь уншихаар авсан ном хэвлэлийн бүрэн бүтэн байдлыг хариуцах ба авсан хугацаандаа төлбөрийг бүрэн төлөх
- 3.3 Ном хэвлэлийг алдаж үрэгдүүлсэн, урж гэмтээсэн, өнгө үзэмжийг бууруулсан, мэдээллийн утгыг алдагдуулсан тохиолдолд "Алдагдсан буюу гэмтээгдсэн ном хэвлэлийг төлүүлэх журам"-ын дагуу төлж номын санг хохиролгүй болгох
- 3.4 Уншигч нь гэрээр ном олгох журмын 2 дахь заалтыг мөрдөж үйлчлүүлнэ.

ДӨРӨВ.НОМ ХЭВЛЭЛИЙГ ТӨЛҮҮЛЭХ

- 4.1 Уншигч буюу номын санч нь номын сангийн захиргаанаас тогтоосон хугацаанд төлбөрөө барагдуулахгүй тохиолдолд дараагийн шатны байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

ТАВ. НОМЫН САНЧИЙН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 5.1 Номын санч нь уншигчдад ном хэвлэл өгөх, буцааж авахдаа шалгаагүйгээс түүний хуудас урагдсан, гэмтсэн алга болсон тохиолдолд тухайн ном хэвлэлийг бүрэн бүтэн болгох
- 5.2. 3-аас дээш хувьтай ном алдаж үрэгдүүлсэн тохиолдолд уг номыг тухайн үеийн ханшаар буюу нөхөн бүрдүүлэх шаардлагатай номоор төлүүлэх
- 5.3. Нэг хувьтай ном, толь бичиг, нэвтэрхий толь зэргийг алдаж үрэгдүүлсэн тохиолдолд номыг номоор нь төлүүлэх
- 5.4. Номын сангийн гэрээр ном олгох журмыг зөрчин гэрээр гаргадаггүй ном хэвлэл / ганц хувь ном, барын ном толь бичиг, нэвтэрхий толь, гэх мэт/-ийг алдаж үрэгдүүлбэл эд хөрөнгийн хохирлыг бүрэн төлүүлэх, арга хэмжээ авах

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САН

